



Дотоо хэргийг түгээн хэргийг
2010 оны 02 дугаар сарын 12
№06 /627/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

195

**Зарим газар нутгийг тусгай
хамгаалалтад авах тухай**

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

199

**Мөнгөн урамшууллын хэмжээ
тогтоох тухай**

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

199

**Ус ашигласны төлбөрийн хувь,
хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------------|--|-----------|-----|
| 60. | Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 04 | 194 |
| 61. | Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр хэрэгжүүлэх “Улаанбаатар хотын Нарангуул олон улсын худалдааны төвийн баруун урд уулзвар болон төмөр зам дээгүүрх гүүрэн гарц барих төсөл”-ийн тухай | Дугаар 05 | 194 |
| 62. | Зарим газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай | Дугаар 06 | 195 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------------|---|------------|-----|
| 63. | Мөнгөн урамшууллын хэмжээ тогтоох тухай | Дугаар 350 | 199 |
| 64. | Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 351 | 199 |
| 65. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай | Дугаар 352 | 202 |
| 66. | Ой тэмдэглэх тухай | Дугаар 355 | 202 |

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

- | | | | |
|------------|--|-----------|-----|
| 67. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай | Дугаар 01 | 206 |
|------------|--|-----------|-----|



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 01 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1.Улсын Их Хурлын гишүүн Яйчилийн Батсуурийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2010 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 01 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 05

Улаанбаатар
хот

Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр хэрэгжүүлэх "Улаанбаатар хотын Нарантуул олон улсын худалдааны төвийн баруун урд уулзвар болон төмөр зам дээгүүрх гүүрэн гарц барих төсөл"-ийн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1.Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр хэрэгжүүлэх "Улаанбаатар хотын Нарантуул олон улсын худалдааны төвийн баруун урд уулзвар болон төмөр зам дээгүүрх гүүрэн гарц барих төсөл"-ийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд 2010-2011 онд барьж гүйцэтгэхийг Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

2.Энэ төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг

уг төсөл хэрэгжиж дууссан жилийн дараахь жилд 50 хувиар, 2 дахь жилд 45 хувиар, 3 дахь жилд 5 хувиар тус тус тооцон жил бүрийн улсын төсөвт тусгуулж байхыг Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 01 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

**Зарим газар нутгийг улсын тусгай
хамгаалалтад авах тухай**

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн, Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр"-ийн 3.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Байгаль орчны тэнцлийг хангах, унаган төрхийг хадгалах, хамгаалах болон байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Завхан аймгийн Цэцэн-Уул, Сантмаргац, Завханмандал, Эрдэнэхайрхан сумдын нутгийн зарим хэсэг болох Улаагчины хар нуур орчмын газар нутгийг, Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдын болон Завхан аймгийн Алдархаан сумын нутгийн зарим хэсгийг хамруулан Монгол элсний орчмын газар нутгийг тус тус байгалийн цогцолборт газрын ангиллаар, Ховд аймгийн Мянгад, Увс аймгийн Өмнеговь сумдын зааг нутагт орших Алтан Хөхий уул орчмын газар нутгийг байгалийн нөөц газрын ангиллаар, Баянхонгор аймгийн Заг сумын нутагт орших Хүрэн бэлчир орчмын газар нутгийг дурсгалт газрын ангиллаар тус тус улсын тусгай хамгаалалтад авсугай.

2."Улаагчины хар нуур орчмын байгалийн цогцолборт газрын хилийн зааг"-ийг 1 дүгээр хавсралтаар, "Монгол элсний орчмын байгалийн цогцолборт газрын хилийн зааг"-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ



Монгол Улсын Их Хурлын 2010 оны 06
дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЗАВХАН АЙМАГ

Улаагчины хар нуур орчмын байгалийн цогцолборт
газрын хилийн зааг

Д/д	Гэзрын нэр	Өндрийн тоот	Х координат	Y координат
1	Барзан уул	1703.0	95 01 35	48 31 24
2	Онцрын хар уул	1645.1	95 11 01	48 30 10
3		1591.0	95 11 40	48 29 33
4		1670.0	95 14 10	48 27 43
5		1522.0	95 16 02	48 27 45
6	Хунт нуурын зүүн хойд үзүүрийн цэг		95 16 44	48 27 46
7	Мухар хүнгүй голыг өгсөж		95 19 37	48 26 33
8	Сантмаргац, Цэцэн-Уул сумын зааг		95 21 13	48 26 29
9	Хоёр сумын хилийн заагаар хойш эргэж Овооны хар уул	1665.8	95 25 29	48 31 19
10	Зээргэнт		95 32 28	48 34 07
11	Жаргалант уул	1803.0	95 32 54	48 35 41
12		1638.0	95 35 48	48 35 31
13		1945.0	95 45 33	48 32 55
14	Шийр ухаа	2102.0	95 48 02	48 31 52
15		2031.0	95 50 57	48 31 24
16	Замын хар уул	2283.4	95 56 39	48 30 08
17	Хар хушуу уул	2238.0	95 59 03	48 29 12
18	Далт уул	2381.0	96 01 53	48 28 05
19	Ухаагийн даваа	2160.0	96 04 52	48 25 37
20	Хөшөөт уул	2281.8	96 09 37	48 24 39
21		2164.9	96 15 12	48 23 48
22		2039.0	96 17 09	48 22 52
23		2370.1	96 17 57	48 20 42
24		2080.0	96 16 53	48 19 09

25		2186.0	96 15 58	48 17 16
26		2507.4	96 14 32	48 16 10
27	Бургастын даваа	2430.0	96 13 23	48 15 42
28		2257.0	96 10 24	48 14 53
29		2318.6	96 02 37	48 12 29
30		2111.0	95 57 14	48 11 21
31	Бэрх уул	2161.0	95 54 18	48 11 43
32		1950.7	95 46 37	48 13 00
33		1912.0	95 43 48	48 12 59
34	Нарийны голын эх		95 41 23	48 14 03
35	Хүнгүй голын эх	1660.0	95 39 10	48 14 01
36		1418.4	95 00 37	48 20 35
37		1602.4	94 57 41	48 22 26
38			94 59 00	48 23 28
39		1491.0	94 59 55	48 26 49
40	Бор шанаа	1781.4	95 00 17	48 28 53
41	Барзан уул	1703.0	95 01 35	48 31 24

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ГОВЬ-АЛТАЙ, ЗАВХАН АЙМАГ

Монгол элсний орчмын байгалийн цогцолборт газрын хилийн зааг

Д/д	Газрын нэр	Өндрийн тоот	X координат	Y координат
1	Ногоон толгойгоос хойш 1 км-т 2 аймгийн хилийн заагт орших цэг	1266.3	94 18 00	47 42 55
2	Завхан голын урд эргийг даган голоо өгсөж Баян-Уул, Хөх морьт сумын хилийн зааг		95 05 57	47 33 06
3	Завхан голын урд эргийг даган голоо өгсөж Арлын дээд үзүүр		95 26 22	47 33 33



4	Завхан голын урд эргийг даган голоо өгсөж Алдархаан, Жаргалан сумын хилийн зааг		95 52 16	47 23 03
5		1447.0	95 47 16	47 19 12
6		1453.3	95 45 32	47 18 30
7		1442.0	95 36 22	47 18 15
8	Баян цахир уул	1682.6	95 31 56	47 19 00
9	Баян-Уул, Жаргалан сумын хилийн зааг	1532.5	95 27 36	47 19 41
10	Солжир уул	1852.5	95 22 42	47 20 26
11		1517.4	95 17 49	47 20 33
12	Цахир уул	1452.9	95 11 29	47 20 37
13		1369.0	95 04 51	47 23 08
14	Зэгст нуурын зүүн үзүүр		95 02 04	47 23 35
15	Сангийн далай нуурын зүүн урд үзүүр	1354.5	95 00 08	47 23 26
16	Улаан толгой	1464.9	94 50 51	47 25 19
17		1756.0	94 44 51	47 25 34
18	Тогоотын уул	1763.0	94 41 30	47 25 36
19		1589.9	94 33 06	47 25 03
20		1542.2	94 29 51	47 24 29
21		1320.5	94 17 49	47 25 11
22	Дөрөлжийн худаг		94 23 10	47 29 57
23	Наран булагийн худаг		94 23 47	47 31 39
24		1461.0	94 24 16	47 33 27
25		1399.5	94 24 29	47 35 50
26	Баян өндөр уул	1505.3	94 22 58	47 37 16
27		1398.6	94 18 44	47 38 17
28	Өндөр хар уул	1464.4	94 17 57	47 40 12
29		1297.0	94 17 30	47 41 12
30	Ногоон толгойгоос хойш 1 км-т 2 аймгийн хилийн заагт орших цэг	1266.3	94 18 00	47 42 55

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 11 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 350

Улаанбаатар
хот

Мөнгөн урамшууллын хэмжээ тогтоох тухай

Тариалангийн тухай хуулийн 15¹.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдэд тэдгээрийн улсад болон гурилын үйлдвэрт нийлүүлсэн хүнсний буудайн нэг тонн тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээг 50.0 (тавин) мянган төгрөг байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Урамшуулал олгох тухай" Засгийн газрын 2007 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 227 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 47 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 11 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 351

Улаанбаатар
хот

Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Ус ашигласны төлбөрийн хувь, хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төлбөрийн хувь, хэмжээг



тогтоох тухай” Засгийн газрын 2005 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 7 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Л.ГАНСҮХ

Засгийн газрын 2009 оны 351 дүгээр
тогтоолын хавсралт

УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ

Ус ашиглалтын зориулалт	Хэмжих нэгж	Ус ашигласны төлбөр	
		Гадаргын ус	Газрын доорхи ус
I. Усан цахилгаан станц, усан замын тээвэр, усны түгээмэл тархацтай амьтан, ургамал үржүүлэх, аялал зугаалга, биеийн тамирын зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний борлуулалтын орлогын дүнгээс	хувь	1.0	-
II. Уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд:			
а) ашигт малтмал олборлох, баяжуулах	төг	100	150
б) зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах	төг	80	150
в) усыг шавхан зайлуулах	төг	-	50
г) эрэл, хайгуулын өрөмдлөг хийх	төг	50	100
III. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд:			

1. Хүнд үйлдвэрлэлд	төг	20	50
2. Хөнгөн үйлдвэрлэлд	төг	20	50
3. Авто зам, засварт	төг	20	50
4. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлд	төг	20	50
5. Хүнсний үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд:			
а) архи, пиво, согтууруулах ундаа	төг	20	50
б) ундаа, цэвэр ус		10	40
в) талх, чихэр, нарийн боов, бусад		10	30
6. Эрчим хүчний үйлдвэрлэлд	төг	10	30
7. Газар тариалангийн үйлдвэрлэлд	төг	10	30
8. Бусад ашиг олох зориулалтаар ашигласан усны шоометр тутамд:			
а) Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот	төг	20	50
б) Баян-Өлгий, Ховд, Увс, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Завхан, Архангай, Өвөрхангай, Дорнод, Хэнтий аймгийн төв, бусад хот, суурин газар	төг	20	40
в) Баянхонгор, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Говь-Алтай, Говьсүмбэр, Өмнөговь аймгийн төв, бусад хот, суурин газар	төг	20	50

Тайлбар: 1. Хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, ерхийн хүнсний ногооны талбайг услахад ашигласан усыг төлбөрөөс чөлөөлнө.

2. Энэхүү хавсралтын III.8-д заасан аймаг, хот, суурин газрын аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ус ашигласны төлбөрийг ус түгээгч тооцож авна.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 352

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2004 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 135 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх онц чухал объектын жагсаалт"-ын "Нэг, Дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад байх объектууд" гэсэн хэсэгт "12. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын төв байр" гэж нэмсүгэй.

2. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын төв байрыг Дотоодын цэргийн төсөвт хамгаалалтад авсантай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын харуул хамгаалалтын 4 орон тоог цалингийн сангийн хамт Дотоодын цэрэгт шилжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 12 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 355

Улаанбаатар
хот

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 163 дугаар зарлигийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ардчилал, хүний эрхийн өдөр"-2009 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойг тэмдэглэсүгэй.

2. Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД**

Н.АЛТАНХУЯГ

Засгийн газрын 2009 оны 355 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН 20 ЖИЛИЙН ОЙН
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ
БҮХИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга	-Монгол Улсын Ерөнхий сайд
Орлогч дарга	-Тэргүүн шадар сайд
Гишүүд:	-Сангийн сайд; -Гадаад харилцааны сайд; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд; -Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд; -Эрүүл мэндийн сайд; -Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга (зөвшилцсөнөөр); -Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга (зөвшилцсөнөөр); -Нийслэлийн Засаг даргын орлогч.
Нарийн бичгийн дарга	-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга



Засгийн газрын 2009 оны 355 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН
20 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД
ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийхээр төлөвлөж байгаа ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медалийн загвар гаргаж Улсын Их Хурлаар батлуулан, захиалж хийлгэх	2009. XII/02-09	Тэргүүн шадар сайд
2	Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль олгох журам боловсруулж батлуулах	2009. XII/09	Тэргүүн шадар сайд
3	Үндэсний түүхийн музейд "Ардчилал-20" сэдэвт үзэсгэлэн гаргах	2010.1/10	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
4	Хэлмэгдэгсдийн музейн үзмэрийг баяжуулж, зарим үзмэрийг сэргээн засварлах	2009. XII/04- 2010. III/01	Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
5	Төв гудамждагуухь сурталчилгааны самбаруудад ойн логоны анонс, хэвлэмэл хуудас байршуулах	2009. XII/10-20	Нийслэлийн Засаг даргын орлогч
6	Ардчилсан хувьсгалын 20 жилийн түүх, ололт амжилт, үнэт зүйлсийг тайлбарласан нийтлэлийг өдөр тутмын хэвлэлд гаргах, вэб сайтад байршуулах, нэвтрүүлэг, уулзалт ярилцлагыг радио, телевизээр бэлтгэж цацах	2009. XII/09- 2010. XII/16	Тэргүүн шадар сайд

7	"Ардчилал 20 жилд" сэдэвт номын яармаг худалдаа зохион байгуулах	2010.IX сар	Боловсрол, соёл, шинэчлэх ухааны сайд
8	Ардчиллын 20 жилийн ойд зориулан хэвлэлийн бага хурал зохион байгуулах	2010 он	Тэргүүн шадар сайд
9	Үндэсний бөхийн барилдаан зохион байгуулах	2009. XII/10	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
10	Улсын Их Хурлын хүндэтгэлийн чуулган хуралдуулах	2009. XII/10	УИХ-ын Тамгын газрын дарга
11	Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн баярын хурал	2009. XII/10	Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
12	Хүндэтгэлийн хүлээн авалт	2010 он	Тэргүүн шадар сайд, Сангийн сайд
13	Ардчиллын түүхэн баримтат кино бүтээх	2009. XII/01-2010. IX/01	Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
14	Ардчиллын 20 жилийн ойн арга хэмжээний үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн радио, телевизээр дамжуулах	2009. XII/10-20	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2010 оны 01 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 26 ДУГААР ЗҮЙЛИЙН 26.3.6 ДАХЬ ЗААЛТ ҮНДСЭН ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТЫГ ЗӨРЧСӨН ЭСЭХ ТУХАЙ МАРГААНЫГ ЭЦЭСЛЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУХАЙ

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд Н.Жанцан, П.Очирбат, Ж.Болдбаатар, Ж.Амарсанаа, Ц.Сарантуяа, Д.Мөнхгэрэл, Б.Пүрэвням /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Г.Агар-Эрдэнийг оролцуулан Цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Цэцийн хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Д.Очирбат, мэдээлэл гаргагч иргэн Б.Лхагважав нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Лхагважав 2009 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

"...Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь хэсэгт зааснаар "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" 26 дугаар зүйлийн 26.3 дахь заалтын дагуу нам, эвслийг Сонгуулийн ерөнхий хороо бүртгэхээс

татгалзаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9/ дэх заалт "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...", Арван зургадугаар зүйлийн 10/ дахь заалт "...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ...хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх..." тухай Үндсэн хуулийн хэм хэмжээг тус тус зөрчсөн байна" гээд.

"Нам, эвсэл нь сонгуулийн зардлын тайланг гаргаж өгөөгүй, эвсэл хоцруулсан алдаатай үйлдлийнхээ төлөө Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.8 дахь хэсгийн заалтын дагуу 800000-1000000 хүртэл төгрөгөөр торгуулах шийтгэл хүлээж байгаа. Гэтэл энэхүү нэг удаагийн алдаатай үйлдлийнхээ төлөө дахин сонгуульд оролцох эрхээ хасуулна гэдэг нь хууль зүйн шинэжлэх ухааны нэг алдаанд нэг шийтгэл оногдуулах зарчмыг алдагдуулж байна. Аль нэг намын хариуцлагагүй ажилтны алдаанаас болж бусад гишүүд болон ирээдүйн гишүүд, дэмжигчдийн ардчиллын үнэт зүйлс болсон сонгох, сонгогдох эрхийг хязгаарлах нь утгагүй юм.

Иймд Монгол Улсын иргэний эрхэд халдсан, Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн дээр дурдсан заалтыг хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

Хоёр. Иргэн Б.Лхагважав Үндсэн хуулийн цэцэд 2009 оны 9 дүгээр сарын 30-ний өдөр ирүүлсэн нэмэлт тайлбартаа:

"...Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт нь Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Улс төрийн намын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д заасан "Монгол Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох эрхтэй" гэснийг зөрчиж байна.

Улс төрийн намын энэ чухал эрх нь Улс төрийн намын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэгт заасны дагуу л алга болно. Эндээс үүдээд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт нь намын дотоод асуудалд шүүхийн ч оролцдоггүй үйл ажиллагаанд оролцсон, мөн Улсын Дээд шүүхийн бүрэн эрх буюу Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн

1 дэх хэсгийн 5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Улс төрийн намын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.3, 3.6 дахь хэсгийн заалтуудаар хангагдах намд эвлэлдэн нэгдэх Монгол Улсын иргэний эрхэд халдаж байгаа нь Үндсэн хуулийн цэцэд өмнө гаргасан мэдээлэлтэй утга адил юм” гэжээ.

Гурав. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Б.Чойжилсүрэн нар Үндсэн хуулийн цэцэд хандаж 2009 оны 10 дугаар сарын 19-ний өдөр ирүүлсэн тайлбартаа:

“Нэг. “Нам, эвсэл нь сонгуулийн зардлын тайланг гаргаж өгөөгүй, эвсэл хоцруулсан алдаатай үйлдлийнхээ төлөө Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.8 дахь хэсэгт заасны дагуу 800000-1000000 төгрөгөөр торгуулах шийтгэл эдэлж байгаа. Гэтэл энэхүү нэг удаагийн алдаатай үйлдлийн төлөө дахин сонгуульд оролцох эрхээ хасуулна гэдэг нь хууль зүйн ухааны нэг алдаанд нэг шийтгэл ногдуулдаг зарчмыг алдагдуулж байна. Аль нэг намын хариуцлагагүй ажилтны алдаанаас болж бусад гишүүд болон ирээдүйн гишүүд, дэмжигч нарын ардчиллын үнэт зүйл болох сонгох, сонгогдох эрх нь хязгаарлагдах нь” гэсэн талаар:

Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлд нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл гэж заасан бөгөөд нам нь үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх, үйл ажиллагаагаа ил тод явуулах зарчмыг баримтлахаар заасан байдаг.

Сонгуулийн санхүүжилтийн үйл ажиллагааны бүх явц, үр дүнгийн нэг гол үндэслэл, хэлбэр нь сонгуулийн санхүүгийн тайлан юм. Энэ нь угтаа сонгуулийн хуулийн биелэлтийн мөнгөн илэрхийлэл, хяналтын гол хэлбэр болно.

Ийм учраас сонгуульд оролцсон нам, эвсэл нь сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж өгөөгүй тохиолдолд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.8-д заасны дагуу 800000-1000000 төгрөгөөр торгох захиргааны

шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба харин мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6-д заасан Сонгуулийн ерөнхий хорооноос нам, эвслийг бүртгэхээс татгалзах зохицуулалт нь уг зөрчилд давхар оногдуулж буй шийтгэл бус харин дараагийн нөхөн сонгууль болон ээлжит сонгууль явагдахад өмнөх сонгуулийн дараа гарч байсан холбогдох зөрчил арилаагүй, үргэлжилсээр байх тохиолдолд, өөрөөр хэлбэл, өмнөх сонгуулийн зардлын тайланг гаргаж өгөөгүй хэвээр байгаа тохиолдолд авч буй хариуцлагын арга хэмжээ юм.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан "...төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй...", мөн зүйлийн 10 дахь хэсэгт заасан "Аль нэг нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно..." гэснийг зөрчсөн гэсэн талаар:

Хүний сонгох, сонгогдох эрхийг хангах, уг эрх хэрэгжих нэг үндэс нь сонгогчид бүхэлдээ сонгуулийн талаар мэдээллээр хангагдах явдал юм.

Сонгуулийн шударга, ил тод байх, хууль дээдлэх зарчмыг хангах үндсэн зарчмын нэг болсон санхүүжилтийн ил тод байдлыг зөрчиж, хуульд заасан үүргээ дараагийн сонгууль зарлах хүртэл хугацаанд биелүүлээгүй улс төрийн намыг сонгуульд бүртгэхээс татгалзах талаар зохицуулсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтын зохицуулалт нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хязгаарлаж байгаа бус, харин ч иргэд шударга, чөлөөт сонгуулийн үндсэн дээр сонгуулийн эрхээ хэрэгжүүлэх хууль зүйн баталгаа болж байна гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгт болон Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу "...нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх...", "...үйл ажиллагаагаа ил тод явуулах..." зарчмыг хэрэгжүүлэх нь улс төрийн намын үүрэг байдаг.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар өмнөх сонгуулийн зардлын тайлангаа гаргаж өгөх үүргийг сонгуульд оролцсон улс төрийн намуудад бүгдэд нь нэгэн адил хүлээлгэдэг бөгөөд харин хуулийн шаардлагыг дараагийн сонгууль хүртэлх хугацаанд биелүүлээгүй зөрчил гаргасан улс төрийн намыг Сонгуулийн ерөнхий хорооноос бүртгэхээс

татгалздаг зохицуулалт нь тухайн хууль зөрчсөн улс төрийн намд хуулийн дагуу хариуцлага оногдуулж байгаа асуудал бөгөөд үүнийг тухайн намын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхсан, хэлмэгдүүлсэн, аль нэг намд давуу эрх олгосон зохицуулалт гэх хууль зүйн үндэслэлгүй болно.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх..." гэсэн хэм хэмжээг зөрчсөн гэсэн талаар:

Сонгуульд оролцогч улс төрийн нам, нэр дэвшигчид сонгуулийн дансанд оруулсан хөрөнгийг хуульд заасан зориулалт, хязгаарлалтын хүрээнд ашиглах, сонгуулийн санхүүжилт, зардлыг нээлттэй ил тод байлгах асуудал нь сонгуулийн тэгш, шударга байдлыг хангах, иргэний улс төрийн эрхийг баталгаатай хангах үндэс болно. Сонгогч нь сонгуульд нэр дэвшигч, сонгогдогчийн үйл ажиллагааны талаар аливаа мэдээлэл, түүний дотор сонгуулийн санхүүжилт, хандивтай холбоотой мэдээлэл авах эрхтэй. Энэ нь сонгуулиар далимдуулан хууль бусаар мөнгө хуримтлуулах, төсвийн хөрөнгийг ашиглах зэрэг санхүүгийн булхайг таслан зогсооход тун чухал.

Иймд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтын зохицуулалт нь сонгуулийг нээлттэй ил тод, шударга, үр дүн нь бодитой байх, улмаар иргэдийн сонгуулийн эрхийг хангах хууль зүйн нэг гол баталгаа болсон гэж үзэж байна" гэжээ.

Дөрөв. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц энэхүү маргааныг 2009 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн Дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцээд 04 дүгээр дүгнэлтийг гаргасан болно. Уг дүгнэлтийн тогтоох хэсэгт:

"1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нам, эвслийг бүртгэхээс татгалзах үндэслэлийг заасан 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9/ дэх заалтын "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", мөн зүйлийн 10/ дахь заалтын "...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно..." гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар

зүйлийн 26.3.6 дахь заалт нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ...хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх...". Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын "хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх" гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтын "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэсэн хэсгийн үйлчлэлийг 2009 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй" гэжээ.

Тав. Монгол Улсын Их Хурал 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн "Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай" 86 дугаар тогтоолдоо:

"...1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9/ дэх заалтын "төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", мөн зүйлийн 10/ дахь заалтын "Аль нэгэн нам, ... гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно" гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй" гэжээ.

Зургаа. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдорж, Д.Очирбат нар Үндсэн хуулийн цэцэд хандаж 2010 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр ирүүлсэн тайлбартаа:

"2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 04 дүгээр дүгнэлтийг Монгол Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэн 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоол гаргасантай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдаанаар дахин хянан шийдвэрлүүлэхээр байна.



...1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9/ дэх заалтын "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй" гэснийг зөрчсөн гэсэн талаар:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно", мөн зүйлийн 4 дэх хэсэгт "Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно" гэж заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлд Монгол Улсын иргэн нь "сонгогдох" эрхээ дараахь 2 арга замаар хэрэгжүүлж болох боломжийг тусгасан. Үүнд:

1. Сонгууль зарпахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн нам буюу намуудын сонгуулийн эвсэл Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

2. Монгол Улсын сонгогдох эрх бүхий иргэн тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй сонгогчийн дэмжлэг авсан нөхцөлд Улсын Их Хурлын гишүүнд нэрээ бие даан дэвшүүлэх эрхтэй.

Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын сонгуульд сонгогдох эрхээ улс төрийн намаар дамжуулж биш шууд бие даах замаар эдэлж байгаа бол сонгуулийн эрх зүйн харилцаанд оролцогч-бие даан нэр дэвшигч болон сонгуулийн байгууллагын хооронд шууд харилцаа үүсдэг.

Харин Монгол Улсын иргэн сонгогдох эрхээ улс төрийн намаар дамжуулан хэрэгжүүлж байгаа бол намын дүрэм, мөрийн хөтөлбөрт нийцүүлэн, намын Их Хурал, эсхүл түүнээс сонгож байгуулсан намын төлөөллийн төв байгууллагаар дамжуулан хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл улс төрийн нам сонгуулийн эрх зүйн харилцаанд оролцохдоо бие даасан субъект болж оролцдог бөгөөд улс төрийн намаар дамжуулан сонгогдох эрхээ хэрэгжүүлж буй нэр дэвшигчийн хувьд тухайн этгээд болон сонгуулийн байгууллагын хооронд шууд харилцаа үүсдэггүй, улс төрийн намаар дамжуулан сонгуулийн эрх зүйн харилцаанд оролцож байдаг, улс төрийн нам нь тухай иргэний болон сонгуулийн байгууллагын хооронд харилцах "гүүр" болж, гишүүнийхээ сонгогдох эрхийг хангах талаар тодорхой хууль зүйн үүрэг хүлээдэг.

Иргэний сонгогдох эрх нь тухайн сонгуулийн албан тушаалд

тавигдах тусгай шаардлагыг харгалзсан, хууль ёсны болзлыг хангасан байхыг шаарддаг бөгөөд уг хууль ёсны болзол шаардлагыг хангах талаар тухайн иргэнийг нэр дэвшүүлэх гэж буй улс төрийн нам мөн адил хууль зүйн үүрэг хүлээдэг.

Улс төрийн нам уг хууль зүйн үүргээ биелүүлээгүйгээс болж сонгуульд тухайн намаас нэр дэвшиж оролцох эрхээ алдаж буй тухайн намын гишүүн - иргэний хувьд сонгогдох эрхээ өөр байдлаар хэрэгжүүлэх эрх нь нээлттэй хэвээр байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын "...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно..." гэснийг зөрчсөн гэсэн талаар:

Улс төрийн намын тухай хуулийн 4 дүгээр зүйлд "Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн" гэж заасан бөгөөд нам нь үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх, үйл ажиллагаагаа ил тод явуулах зарчмыг баримтлахаар заасан байдаг.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10/ дахь хэсэгт "Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ" гэж заасан байна.

Улс төрийн нам бол тодорхой нарийн бүтэц зохион байгуулалттай, хууль зүйн үүрэг хүлээж, эрх эдэлж буй хуулийн этгээд болохын хувьд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх төрийн эрх барих дээд байгууллагад сонгогдохын тулд хуульд заасан шаардлагыг биелүүлэх, зөрчлөө арилгах чадвартай байх нь зүй ёсны хэрэг бөгөөд Улс төрийн намын тухай хуульд намын санхүүгийн тайлан гаргах үүрэгтэй нэгжийн талаар тусгайлан зохицуулсан байна. Тухайлбал, Улс төрийн намын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д намын санхүүгийн үйл ажиллагаанд тухайн намын хяналтын байгууллага хяналт тавихаар заасан бөгөөд намын төв байгууллага нь харьяа байгууллагын санхүүгийн тайлан



гаргасны дараа нэгдсэн тайлан гаргахаар тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөр болон нэр дэвшүүлэх асуудлыг намын Их Хурал, эсхүл намын Их Хурлаас сонгож байгуулсан намын төлөөллийн төв байгууллага шийдвэрлэхээр хуульд заасан. Нам, эвсэл сонгуульд оролцох тухайгаа санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр илэрхийлж, албан ёсоор бүртгүүлэх ба бүртгүүлэхдээ хуульд заасан баримт бичгийг бүрдүүлэх, бусад шаардлагыг хангасан байх талаар бүртгүүлэхээс өмнө тухайн намын Их Хурал, эсхүл намын Их Хурлаас сонгож байгуулсан намын төлөөллийн төв байгууллага нь шийдвэрлэх бүрэн боломжтой юм.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7-д нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн хандив авахыг хориглосон этгээдийг тодорхой зааж өгсөн бөгөөд энэ заалтад заасан этгээдээс хандив авч зарцуулсан нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах хүртэл арга хэмжээг Сонгуулийн ерөнхий хороо авахаар хуульд заасан байна.

Улс төрийн намын сонгуулийн хууль бус санхүүжилт нь санал худалдаж авах, улс төрийн нам, нэр дэвшигчид гадаад, дотоодын хандивлагчдын эрхшээлд орох, өөрөөр хэлбэл улс төрийн намд хандив өгөөд түүнийхээ хариуд хууль бусаар давуу тал олж авах, төрийн эрх мэдэл эх үүсвэрийг сонгуулийн ажилд урвуулан ашиглах зэрэг зүй зохисгүй үйлдэлд хүргэж авилгалын үр дагаврыг бий болгож, улмаар Үндэсний аюулгүй байдалд заналхийлэх нөхцөл байдлын гол шалтгааны нэг болдог байна.

Иймд Сонгуулийн ерөнхий хороонд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан шаардлага хангаагүй нам, эвслийг бүртгэхээс татгалзах шийдвэр гаргах эрх олгож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан "Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ" гэсэн нөхцөл хангагдах, улмаар Үндэсний аюулгүй байдлыг хангах нэг баталгаа болж байна гэж үзэж байна.

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар өмнөх сонгуулийн

зардлын тайлангаа гаргаж өгөх үүргийг сонгуульд оролцсон улс төрийн намуудад бүгдэд нь нэгэн адил хүлээлгэдэг бөгөөд харин хуулийн шаардлагыг дараагийн сонгууль хүртэлх хугацаанд биелүүлээгүй зөрчил гаргасан улс төрийн намыг Сонгуулийн ерөнхий хорооноос бүртгэхээс татгалздаг зохицуулалт нь тухайн хууль зөрчсөн улс төрийн намд хуулийн дагуу хариуцлага оногдуулж байгаа асуудал бөгөөд үүнийг тухайн намын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхсан, хэлмэгдүүлсэн, аль нэг намд давуу эрх олгосон зохицуулалт гэж үзэхгүй байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Б.Чойжилсүрэн нарын Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарыг дэмжиж байгаагаа мэдэгдье” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт зааснаар Сонгуулийн ерөнхий хороо нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах эрхтэй төрийн байгууллага атал түүнд улс төрийн нам, эвслийг өмнөх сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй, хугацаанд нь ирүүлээгүй гэсэн шалтгаанаар бүртгэхээс татгалзаж сонгуульд оролцох эрхийг хасах эрх хэмжээг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтаар олгосон нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулж байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад “өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9/ дэх заалтын “...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй”, мөн зүйлийн 10/ дахь заалтын “...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно...” гэснийг тус тус зөрчсөн гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 04 дүгээр дүгнэлт нь үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1/, мөн

хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН
ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:**

1. 2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9/ дэх заалтын "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", мөн зүйлийн 10/ дахь заалтын "...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно..." гэснийг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэснийг хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэхүү тогтоол нь гармагцаа хүчин төгөлдөр болно.

**ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД**

**Ж.БЯМБАДОРЖ
Н.ЖАНЦАН
П.ОЧИРБАТ
Ж.БОЛДБААТАР
Ж.АМАРСАНАА
Ц.САРАНТУЯА
Д.МӨНХГЭРЭЛ
Б.ПҮРЭВНЯМ**

Хаяг:

"Төрийн мэдээлэл" захтгалын редакци,
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turin_medeel@parliament.mn
Утас: 262420, 329612
Хэвлэлийн хуудас 1.5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв,
Утас 329487